



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

### Үйлчилгээний ажилчдын гарын авлага бэлтгэж түгээх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/718 дугаар захирамж, тус газрын 2022 оны дүрмийн 4.1.7, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа үйлчилгээний байгууллагын ажилтнуудад зориулсан цахим гарын авлага бэлтгэж, түгээх ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Д.Ганболд)-д үүрэг болгосугай.

2. Цахим гарын авлага бэлтгэж, түгээх ажилд шаардагдах 19,500,000 (Арван есөн сая таван зуун мянган) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.


3. Гарын авлага бэлтгэж түгээх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА *D. Batm* Д.БАТСҮХ



1150509170

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 06 сарын 18 өдрийн  
А/32 дугаар тушаалын хавсралт



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛЧДЫН ГАРЫН АВЛАГА БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨСВИЙН  
ЗАДАРГАА

Д/д	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Гарын авлагын бүтээх багийн ажлын хөлс	3/15 минут	3.500.000	10.500.000
2	Гарын авлагыг дүрсжүүлэх студын ажлын хөлс	3	3.000.000	9.000.000
	Нийт дүн			19.500.000

--o0o--